Орон нутгийн боловсролын байгууллагад олон жил идэвх зүтгэлтэй ажиллаж физик-математикийн сургалт, заах аргад шинэ арга зүйг нэвтрүүлж сурлагын чанарыг дээшлүүлэн, сурагчдаа улс, аймгийн олимпиадад тогтмол амжилттай оролцуулж, залуу багш нарыг сургаж дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь

үнэлж Булган аймгийн Булган сумын I дүгээр дунд сургуулийн багш Сүрэнгийн Цэрэнпилд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 208

Улаанбаатар хот

Санжаажавын Оюунд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Хэвлэл мэдээлэл, утга зохиолын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж сэтгүүл зүй, яруу найргийн болон үргэлжилсэн үгийн олон шилдэг бүтээлүүд туурвиж, монголын орчин үеийн сэтгүүл зүй, уран зохиолыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж

"Болор судар" хэвлэлийн газрын эрхлэгч, сэтгүүлч, яруу найрагч Санжаажавын Оюунд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 209

Улаанбаатар хот

Сэвжидийн Сүхбаатарт Монгол Улсын урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, монгол ардын үндэсний уламжлалт болон орчин үеийн бүжиг, бүжгэн жүжгийг чадварлаг дэглэн найруулж, ардын урлагийг хөгжүүлэх, урын санг баяжуулах, гадаад оронд сурталчлахад оруулсан хувь нэмрийг үнэлж

Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын уран сайхны удирдагч, ерөнхий найруулагч Сэвжидийн Сүхбаатарт Монгол Улсын урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 210

Улаанбаатар хот

Рэнцэнгийн Батмэндэд Монгол Улсын гавъяат эдийн засагч цол хүртээх тухай

Төрийн захиргааны төв байгууллагуудад олон жил үр бүтээлтэй ажиллаж, төрийн эдийн засаг, удирдлагын стратегийн бодлогын чиглэлээр эрдэм шинжилгээ, практикийн ном бичиж нийтлүүлэн, "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого"-ыг боловсруулахад оруулсан хувь нэмрийг нь үнэлж Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн

дэргэдэх Стратеги судалгааны хүрээлэнгийн Нийгэм эдийн засгийн аюулгүй байдлын судалгааны төвийн дарга, доктор Рэнцэнгийн Батмэндэд Монгол Улсын гавъяат эдийн засагч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 211

Улаанбаатар хот

Лханаажавын Цэдэндамбад Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Шинжлэх ухааны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, Монгол Улсыг бүсчилэн хөгжүүлэх ажил, арга зүйн болон практикийн ач холбогдолтой бүтээлүүд туурвиж, "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого"-ыг боловсруулахад оруулсан хувь нэмрийг нь үнэлж Үндэсний хөгжлийн

хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Лханаажавын Цэдэндамбад Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 212

Улаанбаатар хот

Адъяагийн Баярмагнайд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Батлан хамгаалах болон үндэсний спортын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, үндэсний спортын шагайн харваа, хурдан морины уралдааны төрлүүдэд зохион байгуулалт, арга зүйн шинэчлэл хийж, боловсронгуй болгон хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Монголын морин спорт

уяачдын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Адъяагийн Баярмагнайд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 213

Улаанбаатар хот

Муухайн Намсрайд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, мэс заслын эмчилгээ, оношлогооны шинэ аргуудыг эмнэлгийн практикт нэвтрүүлэн, эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулж, хүн амын эрүүл мэндийг хамгаалахад оруулсан хувь нэмрийг нь үнэлж Улсын клиникийн төв эмнэлгийн бөөрний мэс

заслын клиникийн их эмч, профессор Муухайн Намсрайд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 214

Улаанбаатар хот

Дамдинсүрэнгийн Цагаанд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, сургалт, эрдэм шинжилгээний бүтээлүүд туурвин, эмнэлгийн практикт нөхөн сэргээх эмчилгээний шинэ аргуудыг нэвтрүүлж, эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарыг сургаж бэлтгэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улсын

клиникийн II нэгдсэн эмнэлгийн нөхөн сэргээх эмчилгээний тасгийн эрхлэгч, доктор Дамдинсүрэнгийн Цагаанд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 215

Улаанбаатар хот

Сарангэрэлийн Хүрэлбаатарт Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээх тухай

Биеийн тамир, спортын салбарт үр бүтээлтэй ажиллаж самбо, жүдо бөхийн төрлөөр тив, дэлхий, олон улс болон улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд удаа дараа амжилттай оролцон самбо бөхийн дэлхийн залуучуудын аваргын алтан медаль, дэлхийн цомын аваргын мөнгөн медаль хүртэж, бөхийн спортыг хөгжүүлэхэд

оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Хөвсгөлийн хүчтэнүүд" клубын дасгалжуулагч, Монгол Улсын заан Сарангэрэлийн Хүрэлбаатарт Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 216

Улаанбаатар хот

Адуучийн Баатархүүд Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээх тухай

Чөлөөт бөхийн спортын төрлөөр тив, дэлхий, олон улс болон улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд удаа дараа амжилттай оролцож, дэлхийн залуучуудын аваргын анхны алтан медаль, Ази тивийн аваргын мөнгөн медаль хүртсэн амжилтыг нь үнэлж чөлөөт бөхийн спортын олон

улсын хэмжээний мастер Адуучийн Баатархүүд Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 217

Улаанбаатар хот

Хорлоогийн Баярманлайд Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж, дэлхийн сонгодог болон үндэсний олон арван бүжгийн жүжгийн гол ба туслах дүрийг мэргэжлийн өндөр ур чадвар гарган бүтээж, уран бүтээлийнхээ санг баяжуулах, Монгол Улсад сонгодог бүжгийн урлагийг хөгжүүлэх, гадаад оронд сурталчлахад оруулсан хувь нэмрийг үнэлж Улсын

Дуурь бүжгийн эрдмийн театрын гоцлол бүжигчин Хорлоогийн Баярманлайд Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 218

Улаанбаатар хот

Дашбалдангийн Бямбад Монгол Улсын гавъяат малчин цол хүртээх тухай

Мал сүргээ жил бүр тогтвортой өсгөн үржүүлж, сүргийн бүтцийг чанаржуулах, малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, залуу малчдыг мал маллагааны арга ухаанд сургаж, иргэдийг малжуулах, мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

Төв аймгийн Бүрэн сумын Өнжүүл багийн малчин Дашбалдангийн Бямбад Монгол Улсын гавъяат малчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 219

Улаанбаатар хот

Цамбын Даваахүүд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай

Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, цээж, хэвлийн хөндийн нарийн төвөгтэй мэс заслыг мэргэжлийн өндөр түвшинд хийж, эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулан, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, орон нутагт чадварлаг мэс заслын эмч нарыг сургаж бэлтгэхэд оруулж байгаа хувь

нэмрийг нь үнэлж Ховд аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн мэс заслын зөвлөх эмч Цамбын Даваахүүд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 220

Улаанбаатар хот

И Сог У-г "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, БНСУ-ын найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх, монголын боловсролын салбар болон Улаанбаатар хотын хөгжилд оруулсан хувь нэмрийг

нь үнэлж БНСУ-ын Намянжу хотын дарга И Сог У-г "Найрамдал" медалиар шагнасүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 221

Улаанбаатар хот

Үндэсний сурын харваачдад улсын цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Үндэсний их баяр наадам, Их Монгол Улс байгуулагдсаны 802 жилийн ой, Ардын хувьсгалын 87 жилийн ойн баярын Үндэсний сурын эрэгтэйчүүдийн харваанд түрүүлсэн Өмнеговь

аймгийн Номгон сумын уугуул, "Таван толгой транс" компанийн харваач, улсын хошой мэргэн Жанчивян Баттөмөрт "Монгол Улсын гоц мэргэн" цол, эмэгтэйчүүдийн харваанд түрүүлсэн Завхан аймгийн Түдэвтэй сумын уугуул, "Петровис" компанийн харваач Дашцогзолын Эрдэнэтуяад "Улсын мэргэн" цол тус тус олгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 222

Улаанбаатар хот

Улсын начин цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Үндэсний их баяр наадам, Их Монгол Улс байгуулагдсаны 802 жилийн ой, Ардын хувьсгалын 87 жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 5 давсан дараахь бөхчүүдэд "Улсын начин" цол олгосугай.

1. Жадамбаагийн Оргил - Завхан аймгийн Их-Уул сумын харъяат, "Хүч" спорт хороо, Нийслэлийн Хөдөлгөөнт эргүүл хамгаалалтын газар, "Алс" компанийн бөх

2. Шоовдойхүүгийн Тогтохбаяр - Говь-Алтай аймгийн Жаргалан сумын харъяат, "Хилчин" спорт хороо, "Монгол тамхи Со" компанийн бөх

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 223

Улаанбаатар хот

Улсын харцага цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтыг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Үндэсний их баяр наадам, Их Монгол Улс байгуулагдсаны 802 жилийн ой, Ардын хувьсгалын 87 жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 6 давсан дараахь бөхчүүдэд "Улсын харцага" цол олгосугай.

1. Түмэннасангийн Амартүвшин - Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын харъяат, Дотоодын цэргийн 805 дугаар анги, "Ану сервис" компанийн бөх

2. Өлзийбатын Даваабаатар - Төв аймгийн Баянцогт сумын харъяат, Олимп дээд сургууль, "Итгэл-Орших" группийн бөх

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 224

Улаанбаатар хот

Улсын заан цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

давсан Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын харьяат, "Хилчин" спорт хороо, "Газар холдинг" группийн бөх Баттулгын Соронзонболдод "Улсын заан" цол олгосугай.

Үндэсний их баяр наадам, Их Монгол Улс байгуулагдсаны 802 жилийн ой, Ардын хувьсгалын 87 жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 7

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 225

Улаанбаатар хот

Улсын гарьд цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

давсан Говь-Алтай аймгийн Чандмань сумын харьяат, Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, "Хүч" спорт хороо, "Туушин" ХХК-ийн бөх Нямдоржийн Ганбаатарт "Улсын гарьд" цол олгосугай.

Үндэсний их баяр наадам, Их Монгол Улс байгуулагдсаны 802 жилийн ой, Ардын хувьсгалын 87 жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 8

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 226

Улаанбаатар хот

Улсын арслан цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

давж түрүүлсэн Говь-Алтай аймгийн Чандмань сумын харьяат, Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, "Хүч" спорт хороо, "Туушин" ХХК-ийн бөх Нямдоржийн Ганбаатарт "Улсын арслан" цол олгосугай.

Үндэсний их баяр наадам, Их Монгол Улс байгуулагдсаны 802 жилийн ой, Ардын хувьсгалын 87 жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 9

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 227

Улаанбаатар хот

Цагаанхүүгийн Оюундэлгэрт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, орон нутгийн эмнэлгийн материаллаг баазыг бэхжүүлж, эмчилгээ, оношлогооны шинэ аргуудыг эмнэлгийн практикт нэвтрүүлэн, эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулж, хүн амын эрүүл мэндийг хамгаалахад оруулсан хувь нэмрийг нь үнэлж Увс

аймгийн Зүүнхангай сумын хүн эмнэлгийн эрхлэгч, их эмч Цагаанхүүгийн Оюундэлгэрт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 228

Улаанбаатар хот

Зарим хүнийг одонгоор шагнах тухай

Хөдөө аж ахуй, эрүүл мэндийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одонгоор шагнасугай...

хөдөө аж ахуйн газрын дарга
2. Санжийн Дүүдэй - Увс аймгийн Зүүнговь сумын Хүн эмнэлгийн салбарын зөвлөх эмч

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР

1. Чимидийн Ганболд - Увс аймгийн Хүнс,

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 08 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 236

Улаанбаатар хот

Найдангийн Түвшинбаярт Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээх тухай

Бээжин хотноо болсон зуны олимпын XXIX их наадмын жү-до бөхийн төрөлд амжилттай барилдаж, олимпын алтан медаль хүртсэн, дэлхийн цомын болон Ази тивийн аварга шалгаруулах тэмцээний мөнгө, хүрэл медальт, жү-до бөхийн олон улсын

хэмжээний мастер Найдангийн Түвшинбаярт Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 08 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 237

Улаанбаатар хот

Найдангийн Түвшинбаярт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Даян дэлхийн спортын их баяр наадам-зуны олимпын XXIX наадмын жү-до бөхийн төрөлд гарамгай амжилт гарган медалийн эзэн болж Монгол Улсын түүхэнд анх удаа олимпын аварга хэмээх эрхэм дээд алдрыг хүртсэн Найдангийн Түвшинбаярт Монгол

Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 212

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1, Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 35 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2. Шинээр байгуулагдаж байгаа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Ойн хэрэг эрхлэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг батлагдсан төсөвтөө багтаан баталж, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг батлан мөрдүүлж ажиллахыг Байгаль орчны сайд Г.Шийлэгдамбад үүрэг болгосугай.

1. "Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 2002 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 162 дугаар тогтоолын хавсралтын Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээнд "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн хэсэгт "15". Ойн хэрэг эрхлэх газар" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД

Г.ШИЙЛЭГДАМБА



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 227

Улаанбаатар хот

Чөлөөт бүсийн тухай хуулийн 9.1, 18.1, Дотоодын цэргийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Цагааннуур" худалдааны чөлөөт бүсэд ажиллах мэргэжлийн хяналтын албаны орон тооны дээд хязгаарыг 8 хүртэл байхаар, дотоодын цэргийн гэрээт хамгаалалтын орон тооны дээд хязгаарыг 51 хүртэл байхаар тус тус тогтоосугай.

2. Засгийн газрын 2004 оны 135 дугаар тогтоолоор баталсан "Цэрэг, дотоодын цэргийн хамгаалалтад байх онц чухал объектын жагсаалт"-ын хоёрдугаар хэсэгт "5. "Цагааннуур" худалдааны чөлөөт бүс" гэж нэмсүгэй.

"Цагааннуур" худалдааны чөлөөт бүсийн талаар авах зарим арга хэмжээний тухай

3. "Цагааннуур" худалдааны чөлөөт бүс дэх хөрөнгө оруулалтын хэмжээ явц үйл ажиллагааны цар хүрээ зэргийг харгалзан тус чөлөөт бүсэд ажиллах мэргэжлийн хяналтын алба болон дотоодын цэргийн гэрээт хамгаалалтын орон тоо, урсгал зардлыг 2009 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ
САЙД

Х.НАРАНХҮҮ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 233

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9.5, Компанийн тухай хуулийн 2.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Дөргөн сумын Чоно харайхын гол дээр баригдаж байгаа усан цахилгаан станцын үйл ажиллагааг хариуцах "Дөргөний усан цахилгаан станц" хязгаарлагдмал хариуцлагатай компанийг шинээр үүсгэн байгуулж, түүнийг "Баруун бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн охин компанийн хэлбэрээр ажиллуулсугай.

2. Говь-Алтай аймгийн Тайширын усан цахилгаан станц, Завхан, Говь-Алтай аймгийн нутаг дахь цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугам, дэд станцууд, цаашид энэ системд холбогдох Говь-Алтай аймгийн Гуулин, Завхан аймгийн Богдын гол, Тосонцэнгэл, Завханмандал, Цэцэн-Уулын усан цахилгаан станцуудын үйл ажиллагааг хариуцсан "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийг шинээр үүсгэн байгуулсугай.

Төрийн өмчит хувьцаат компани
байгуулах тухай

3. "Алтай-Улиастайн дамжуулах сүлжээ", "Тайшир усан цахилгаан станц", "Гуулин усан цахилгаан станц", "Богдын гол усан цахилгаан станц", "Тосонцэнгэл усан цахилгаан станц", "Завханмандал усан цахилгаан станц", "Цэцэн-Уул усан цахилгаан станц" хязгаарлагдмал хариуцлагатай компаниудыг шинээр үүсгэн байгуулж, тэдгээрийг "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн охин компанийн хэлбэрээр ажиллуулсугай.

4. Шинээр үүсгэн байгуулагдаж байгаа дээр дурдсан төрийн өмчит хувьцаат компаниудад шилжих хөрөнгө, өглөг, өр төлбөр, өөрийн хөрөнгө, гаргах хувьцааны хэмжээ, төрийн өмчид бүртгэх асуудлыг зохион байгуулж хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн хороо (Д.СУГАР)-нд даалгасугай.

5. "Баруун бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компани, "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компани болон түүний охин компаниудын дүрмийг боловсруулан Компанийн тухай хуулийн дагуу батлуулж, эрх бүхий байгууллагад бүртгүүлэн үйл ажиллагааг нь эхлүүлэх, мэргэжлийн боловсон хүчнээр хангах зэрэг арга хэмжээ авч ажиллахыг

Түлш, эрчим хүчний сайд Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн хороо (Д.СУГАР)-нд даалгасугай.

П.Гансүх, Говь-Алтай аймгийн Засаг дарга Р.Цогтбаатар, Түлш, эрчим хүчний сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгасугай.

6. "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компани шинээр зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан Завхан, Говь-Алтай аймгийн эрчим хүчний үйлдвэрүүдийн харьяалал, зохион байгуулалтын асуудлыг судалж саналаа танилцуулахыг Завхан аймгийн Засаг дарга

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**ТҮЛШ, ЭРЧИМ
ХҮЧНИЙ САЙД** **Ч.ХҮРЭЛБААТАР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар 235

Улаанбаатар хот

"Засгийн газарт эрх олгох тухай" Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 42 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Импортын улаан буудайн гурил, хөх тарианы гурил, улаан буудай-хөх тарианы гурил, цагаан будаа, шар будаа, гурвалжин будаа, хөц будаа, элсэн чихэр, ургамлын тос, цөцгийн тос, маргарин, ногоон цай, гахай, шувууны мах (шинэ, хөргөсөн, хөлдөөсөн) загасны мах (шинэ, хөргөсөн, хөлдөөсөн, хатаасан, давсалсан, утсан)-ны гаалийн тарифын хувь хэмжээг 2008 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд "0" байхаар тус тус өөрчлөн тогтоосугай.

Гаалийн тарифын хувь хэмжээг өөрчлөн тогтоох тухай

2. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлж, үнийн өсөлтийг тогтворжуулах асуудалд бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллахыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

САНГИЙН САЙД **Ч.УЛААН**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД** **Ц.ГАНХУЯГ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 238

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13.1, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21.2.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт архидан согтуурахтай тэмцэх, архины хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл заслын аргаар архины хорт зуршлаас ангижруулах, сургалт, сурталчилгаа зохион байгуулах чиг үүргийг "Архидалт мансуурлын эсрэг ассоциаци" төрийн бус байгууллагад хариуцуулан гэрээгээр гүйцэтгүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргилд зөвшөөрсүгэй.

Архидан согтуурахтай тэмцэх, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх талаархи төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх тухай

2. "Архидалт мансуурлын эсрэг ассоциаци" төрийн бус байгууллагыг сургалт, сурталчилгаа явуулах, цуглаан хийх байраар тухай бүр хангаж байхыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

3. "Архидалт мансуурлын эсрэг ассоциаци" төрийн бус байгууллагын архидалтын эсрэг сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд зориулж 41,668.0 (дөчин нэгэн сая зургаан зуун жаран найман мянган) төгрөгийг Эрүүл мэндийг дэмжих сангаас гаргахыг Эрүүл мэндийн сайд Б.Батсэрээдэнэд зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД** **Б.БАТСЭРЭЭДЭНЭ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 239

Улаанбаатар хот

Хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

аюултай бодисын жагсаалт"-ын 57 дахь заалтыг хассугай.

1. "Жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2007 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 95 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон

2. Мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт" д дор дурдсан агуулга бүхий 29 дэх заалт нэмсүгэй.

№	Бодисын ердийн нэр	Химийн нэр, томъёо	Олон улсын бүртгэлийн дугаар	Хэрэглээний түгээмэл хэлбэр	Бодисын онцлог, хоруу шинж чанар
29	Этилений исэл	1,2-epoxyethane; Oxirane; Dimethylene Oxide; (C2HO)	75-21-8	Химийн үйлдвэр, хөлддөггүй шингэн үйлдвэрлэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хадгалалтыг уртасгах, эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, зүү тариурыг ариутгахад	Хорт хавдар үүсгэнэ. Мэдрэлийн систем, генд нөлөөлнө

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД

Б.БАТСЭРЭЭДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 241

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 2007 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 208 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

1. "Олимпын наадам, дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчныг шагнаж урамшуулах журам"-ыг 1 дүгээр, "Мөнгөн шагналын хэмжээ"-г 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД

Б.БАТСЭРЭЭДЭНЭ

Засгийн газрын 2008 оны 241 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ОЛИМПЫН НААДАМ, ДЭЛХИЙ, ТИВИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД АМЖИЛТ ГАРГАСАН ТАМИРЧНЫГ ШАГНАЖ УРАМШУУЛАХ ЖУРАМ

1. Олимпын наадам, дэлхий, тивийн аварга шалгаруулах сонирхогчдын спортын тэмцээнд оролцож амжилт гаргасан тамирчныг Засгийн газраас мөнгөн шагналаар шагнаж урамшуулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

2. Тухайн тэмцээний зэрэглэл, ангилал, жин, зай, төрөлд оролцсон орны тооноос хамгааран тамирчинд дор дурдсан хувь хэмжээний мөнгөн шагналыг олгоно.



№	Тэмцээний		Жин, зай, төрөл тус бүрт оролцсон орны тоо		Олгох мөнгөн шагналын хэмжээ (хувь)
	зэрэглэл	ангилал	эрэгтэй	эмэгтэй	
1	Олимпын наадам	Олимп Паралимп Сурдлимп	Оролцогчийн тоо харгалзахгүй		100
2	Дэлхийн	Дэлхийн аварга Дэлхийн цом Универсиад	32 болон түүнээс дээш	24 болон түүнээс дээш	100
			21-31	17-23	60
			16-20	12-16	30
3	Тивийн	Тивийн наадам, Тивийн аварга	16 болон түүнээс дээш	12 болон түүнээс дээш	100
			12-15	9-11	60
			9-11	6-8	30

3. Тив, бүс нутаг төлөөлсөн дэлхийн цомын төлөөх тэмцээний жин, зай, төрөлд тав болон түүнээс цөөн орны тамирчин оролцсон тохиолдолд тухайн медальд ногдох мөнгөн шагналын 30 хувийг олгоно.

4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын тэмцээнд оролцож медаль хүртсэн тамирчинд энэхүү журмын 2 дугаар заалтад заасан тэмцээний ангилалд ногдох мөнгөн шагналыг олгоно.

5. Залуучуудын олимпын наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчинд оролцсон орны тоог харгалзахгүйгээр Олимпын наадмын шагналын 20 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналыг олгоно.

6. Цувралаар явагддаг дэлхийн цомын төлөөх тэмцээнд тамирчны үзүүлсэн хамгийн өндөр амжилтад тохирох мөнгөн шагналыг тухайн жилд нэг удаа олгоно.

7. Багийн спортын төрлөөр медаль хүртсэн багийн тамирчин тус бүрт оролцсон орны тоог харгалзахгүйгээр медальд ногдох мөнгөн шагналын 30 хувьтай тэнцэх шагналыг олгоно.

8. Тамирчны хувийн болон багийн нэг удаагийн амжилтаар тооцон медаль олгодог спортын төрөлд мөнгөн шагналыг давхардуулан олгохгүйгээр тухайн тамирчны үзүүлсэн хамгийн өндөр амжилтаар тооцон олгоно.

9. Шатар, зуун буудалт даамаар амжилт гаргаж олон улсын их мастер (Гроссмейстер) цол хүртсэн тохиолдолд тивийн аваргын алтан медальд ногдох мөнгөн шагналыг олгоно.

10. Тамирчин нь өөрийн шагналаасаа дасгалжуулагч болон бусад бүрэлдэхүүнд хуваарилах мөнгөний хэмжээг тэдний хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасан хувиар тогтооно.

11. Мөнгөн шагнал авах болзол хангасан тамирчны хамаарах спортын холбоо нь Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад дараахь материалыг

тэмцээн дууссанаас хойш 21 хоногийн дотор ирүүлнэ:

11.1. тухайн тэмцээний албан ёсны урилга, уг тэмцээний заавар, оролцох журам;

11.2. тамирчин, дасгалжуулагч, бусад бүрэлдэхүүний хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээний хувь,

11.3. тэмцээнд оролцох бүрэлдэхүүнийг баталсан биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шийдвэр;

11.4. тэмцээнд медальт байранд шалгарсныг нотолсон баримт, диплом, гэрчилгээ, хуулбарын хамт;

11.5. тухайн тэмцээний протоколыг байрлуулсан интернэтийн вэб сайтын танилцуулга;

11.6. тамирчныг мөнгөн шагналаар шагнуулах хүсэлт;

11.7. залуучууд, өсвөр үеийн тэмцээнд оролцсон тамирчдын төрсний гэрчилгээ болон иргэний үнэмлэхийн хуулбар.

12. Залуучууд, өсвөр үеийн тэмцээнд нас дарж орсон тохиолдолд мөнгөн шагналыг олгохгүй.

13. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэхүү журмын 11 дэх заалтад заасан материалыг хянаж, мөнгөн шагнал олгуулах тухай саналаа биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

14. Мөнгөн шагнал олгуулах саналыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ.

15. Тамирчинд мөнгөн шагнал олгох тухай Засгийн газрын тогтоолыг үндэслэн биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мөнгөн шагналыг олгож, бүрдүүлсэн материалыг хадгална.

МӨНГӨН ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ

(сая.төг)

№	Тэмцээний зэрэглэл	Тэмцээний ангилал	Мөнгөн шагналын хэмжээ (тамирчдын насны ангилал, медалиар)						Залуучууд			Өсвөр үе							
			Насанд хүрэгчид			Алт			Мөнгө			Хүрэл							
			Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл					
1	Олимпийн наадам	Олимп																	
		Паралимп	120.0	60.0	30.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
		Сурдлимп																	
2	Дэлхийн аварга	Дэлхийн аварга	30.0	15.0	8.0	12.0	6.0	3.0	5.0	3.0	2.0	3.0	2.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	
		Дэлхийн цом	20.0	10.0	5.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
		Универсиад	10.0	5.0	3.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	Тивийн аварга	Тивийн наадам	14.0	7.0	4.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
		Тивийн аварга	12.0	6.0	3.0	5.0	3.0	1.0	3.0	2.0	1.0	2.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 245

Улаанбаатар хот

Зээл олгох тухай

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 56.1, Тариалангийн тухай хуулийн 4.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. "Атрын гурав дахь аян"-тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийг Хөвсгөл, Архангай, Увс аймагт хэрэгжүүлэхэд нэмж шаардагдах тус бүр 1.0 (нэг) хүртэл тэрбум төгрөгийг төсвийн зээл хэлбэрээр олгохыг Сангийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

2. "Атрын гурав дахь аян"-тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дээр дурдсан 3 аймагт олгосон зээлийг эргэн төлүүлэх арга хэмжээ аеч ажиллахыг Сангийн сайд Ч.Улаан, Хөвсгөл, Архангай, Увс аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
С.БАЯР
САНГИЙН САЙД
Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 23 ДУГААР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн тухай Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн нэг дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ:

1. Эрүүгийн хуулийн /цаашид "Хуулийн" гэх/ 202 дугаар зүйлийн 202.1-д заасан "**Хортой бодис**" гэж агаар мандлыг бохирдуулах болон хүн, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд хортой нөлөө үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх үйлчилгээтэй биологийн ба химийн бодис, тэдгээрийн нэгдлийг хэлнэ.

2. Хуулийн 203 дугаар зүйлийн 203.1-д заасан "**Хориолсон эргэ, зэвсэг хэрэгсэл**" гэдгийг Ан агнуурын тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар ойлгоно.

Энэ зүйл, хэсэгт заасан "**Ховоран амьтан**"-ы жагсаалтыг Амьтны аймгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6-д зааснаар Засгийн газар батлана.

Мөн зүйл, хэсэгт заасан "**Хориотой үед**" гэдгийг Ан агнуурын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2-т тус тус тодорхойлсон хугацаанаас гадна уг зүйлийн 13.4, 13.5-д зааснаар төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хугацааг зөрчсөнийг ойлгоно.

3. Мөн зүйлийн 2-т заасан "**Нэн ховор эн амьтан**" гэдэгт Амьтны аймгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан амьтан хамаарна.

4. Хуулийн 205 дугаар зүйлийн 205.1-д заасан "**Аюултай хог хаягдал**" гэдгийг Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2-т тус тус зааснаар ойлгох бөгөөд мөн зүйлийн 3.3-т зааснаар аюултай хог хаягдлын ангилал, зэрэглэлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэргэжлийн албадтай хамтран тогтооно.

Мөн зүйл, хэсэгт заасан "**Бусад хог хаягдал**" гэж хэрэглээний болон үйлдвэрлэл, үйлчилгээний явцад үүсэн бий болж, цаашид ямар нэгэн зориулалтаар хэрэглэгдэхгүй болсон бөгөөд аюултай хог хаягдлын ангилал, зэрэглэлд ороогүй эд юмсыг хэлнэ.

5. Хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д заасан "**Үйлдвэрлэлийн хортой хог хаягдал**" гэдэгт энэ тогтоолын 4-т заасан аюултай хог хаягдлаас гадна Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т заасан хог хаягдлыг ойлгоно.

Энэ зүйл, хэсэгт заасан "**Биологийн болон химийн бодис**" гэдэгт эдгээр бодисоос гадна тэдгээрийн нэгдлүүд нэгэн адил хамаарна.

Мөн зүйл, хэсэгт заасан "**Учирч болох байсан**" гэдгийг тухайн нөхцөл байдалд ямар үр дагавар гарах байсныг шүүх хэрэгт авагдсан болон шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэн нотлох баримтын хэмжээнд үнэлж дүгнэнэ.

6. Хуулийн 208 дугаар зүйлийн 208.1-д заасан "**Ан амьтан, шувуу, загас олноор үхсэн болон бусад их хэмжээний хохирол учирсан**"